



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ДЭЛГЭРЦОГТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2018 оны 04 сарын 20 өдөр

Дугаар 444

Амардалай

Ажлын хэсэг томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Автотээвэр болон өөрөө явагч хэрэгслийн албан татварын тухай хуулийн 7-р зүйлийн 7.1, 7.2 дах заалт, 8 дугаар зүйлийн 8.2 дах заалт, Агаарын бохирдлын төлбөрийн тухай хуулийн 9.3 дах хэсэг, Авто замын тухай хуулийн 12.1.3, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн 10.1.1, 10.1.7, 10.1.8 дах заалт, Монгол улсын Засгийн газрын 2016 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 213 дугаар тогтоол, Сангийн сайд, Зам тээврийн хөгжлийн сайдын хамтарсан 2017 оны 01 дүгээр сарын 30-ны өдрийн 34/19 дүгээр тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

Нэг. Тус суманд Автотээврийн хэрэгслийн шинэчилсэн бүртгэл, техникийн хяналтын улсын үзлэг тооллого явуулах, албан татвар, төлбөр, хураамжийг хуулийн дагуу бүрдүүлж, сумын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй байгууллага, ААН, иргэдийн эзэмшилд байгаа бүх төрлийн тээврийн хэрэгслийг шинэчилсэн тоо бүртгэлд оруулах ажлыг зохион байгуулж явуулах ажлын хэсгийг доорхи бүрэлдэхүүнтэй томилсугай.

Үүнд: Ажлын хэсгийн ахлагч: Г. Уугантуяа (Санхүү албаны дарга)

Нарийн бичгийн дарга: Д. Ганчимэг (Татварын улсын байцаагч)

Гишүүд: Л. Отгонбаатар (Сумын хэсгийн мөрдөгч, цагдаагийн дэслэгч)

П. Амгаланбаатар (1 дүгээр багийн Засаг дарга)

Г. Сосорбурам (2 дугаар багийн Засаг дарга)

Б. Баатарсүрэн (3 дугаар багийн Засаг дарга)

Б.Баярмаа (ЗДТГазрын нярав)

Хоёр. Комиссын гишүүд сум орон нутагт байгаа автомашин болон өөрөө явагч хэрэгслийн үзлэг тооллого явуулахад шаардагдах бүх бэлтгэл ажлыг хангаж, техникийн улсын үзлэг тооллогыг цаг хугацаанд нь явуулан, тайлан мэдээг холбогдох газарт тавьж шийдвэрлүүлэхийг ажлын хэсгийн дарга (Г. Уугантуяа)-д даалгасугай.

ДАРГА

М.БАЯРСҮХ

4880200509